



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 311

Улаанбаатар хот

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн
үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйл, Хорооны 2014 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20 дахь зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн нийт гаргасан 370,311,200 /Гурван зуун далан сая гурван зуун арван нэгэн мянга хоёр зуун/ ширхэг энгийн хувьцааг 62,679,220 /жаран хоёр сая зургаан зуун далан есөн мянга хоёр зуун хорь/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 432,990,420 /дөрвөн зуун гучин хоёр сая есөн зуун ерэн мянга дөрвөн зуун хорь/ ширхэг хувьцаатай байхаар үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т. Гандулам/, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК / Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Ж. Алдаржавхлан /-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь Санхүүгийн зохицуулах хороонд тогтмол ирүүлж, хууль тогтоомж болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК /Ч. Чинбат/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээллэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-т, Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-т, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



3. НАРАНТУЯА

000914